



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2015 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/511

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр  
гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны яам болон Германы эрдмийн солилцооны албаны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан Хамтарсан тэтгэлгийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ширчинбал овогтой Мишээлийг 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Фрайбергийн технологийн их сургуульд бакалаврын сургалтад суралцуулсугай.
2. Ш.Мишээл болон хавсралтад заасан хугацаанд герман хэлний сургалтад суралцсан иргэдтэй гэрээ байгуулах, Германы эрдмийн солилцооны албаны нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоог тус тус хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР



Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2015 оны 12 сарын 23 ны өдрийн  
... дугаар тушаалын хавсралт  
А/571

Хамтарсан тэтгэлгийн хөтөлбөрийн хүрээнд  
герман хэлний сургалтад хамрагдсан иргэдийн нэр

№	Овог	Нэр	Суралцсан хугацаа
1	Баатархүү	Гомбожав	1 сар
2	Баттулга	Билгүүн	1 сар
3	Энхбаатар	Энхбаяр	1 сар
4	Энхболд	Хүслэн	1 сар
5	Орхонтуул	Золзаяа	1 сар

---000---